

# ТОЙМ

---



**ОЛОН УЛСЫН  
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.08.19

*Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв*

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Алтны ханш огцом өсөж, 2500 ам.долларыг давлаа.
- Варрен Баффет хувьцааны багцаа шинэчилсэн ба SIRI, ULTA, HEIA компаниуд дахь эзэмшлээ нэмэгдүүлсэн байна. Харин PARA, SNOW зэрэг тикертэй хувьцаануудаа заржээ.
- БНХАУ-ын зах зээлийн гигант Tencent компанийн ашиг 82%-иар өслөө.
- АНУ-ын инфляцын түвшин 2.9% буюу сүүлийн 3 жилийн хамгийн доод түвшинд хүрэв.
- Эдийн засгийн “soft landig” хүлээлт нэмэгдэж, S&P 500 индекс дахин сэргэлээ

2024 он 8-р сарын 19

Dow Jones	40,659.76
S&P 500	5,554.25
Nasdaq	17,631.72
DAX	18,322.40
FTSE 100	8,311.41
S&P/ASX 200	7,971.50
HANG SENG	17,599.00


АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	0.24%	3.31%	0.92%	7.88%	17.85%	15.77%
S&P 500	0.20%	3.93%	0.89%	16.45%	27.11%	25.05%
Nasdaq	0.21%	5.07%	-0.54%	17.46%	32.66%	19.82%
2024 оны 8 сарын 19-ний 11:00						



Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	0.77%	3.36%	0.83%	9.38%	17.65%	15.91%
FTSE 100	-0.43%	1.23%	1.91%	7.48%	14.44%	17.26%
2024 оны 8 сарын 19-ний 11:00						



Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	0.02%	2.04%	0.02%	5.04%	11.54%	6.87%
Hang Seng	1.12%	3.02%	1.21%	3.41%	-1.79%	-29.06%
2024 оны 8 сарын 19-ний 11:00						





## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### Эдийн засгийн “soft landig” хүлээлт нэмэгдэж, S&P 500 индекс дахин сэргэлээ

Эдийн засгийн удаашралын талаарх санаа зовнилыг арилгасан худалдааны мэдээлэл, инфляц болон үйлдвэрлэгчдийн үнийн тайлангууд нь зах зээлийн сэргэлтийг дэмжээд байна. 9-р сард ХНС хүүгээ 50 суурь нэгжээр бууруулах магадлал 25% байгаа бол 25 суурь нэгжээр бууруулах магадлал 75% байна. Энэ жил S&P 500 индекс 16%-иар өссөн бөгөөд 7-р сарын бүх цаг үеийн дээд түвшнээс ойролцоогоор 2%-иар бага байна.

### 7-р сарын эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн мэдээ гарлаа

- **Жижиглэн худалдаа:** 7-р сард 1.0%-иар өсөж, сүүлийн 18 сарын хамгийн өндөр үзүүлэлт байлаа. Энэ нь автомашины борлуулалт болон хэрэглэгчдийн нэмэлт худалдан авалттай холбоотой.
- **Хэрэглээний үнийн индекс (CPI):** АНУ-ын 7 сарын инфляц жилийн дүнгээр 2.9%-д хүрсэн нь өмнөх сарын 3%-иас буурсан үзүүлэлт бөгөөд 2021 оноос хойших хамгийн бага өсөлт юм. Инфляц нь түрээс болон орон сууцны зардлын улмаас өсөж байсан ч компаниуд үнийн өсөлтөө хязгаарлаж эхэлснээр энэ чиг хандлага удахгүй буурах магадлалтай байгаа юм. Ийнхүү үнийн өсөлт удааширч, ажиллах хүчний зах зээл бага зэрэг суларч байгаа нь Холбооны Нөөцийн Санг хүүгийн хэмжээг бууруулахад нөлөөлж болзошгүй юм.
- **Үйлдвэрлэгчдийн үнийн индекс (PPI):** АНУ-ын үйлдвэрлэгчдийн 7 сарын үнийн индекс 0.1%-иар өссөн ч эдийн засагчдын хүлээж байсан 0.2%-ийн өсөлтөөс бага байв. Хүлээлтээс бага гарсан нь бодлогын хүүг бууруулахыг дэмжиж буй хүмүүст эерэг дохио өгч байна.

### Орон сууцны зах зээл

Баасан гарагт АНУ-ын Худалдааны яамнаас гаргасан тайланд барилгын зөвшөөрөл анх удаа 2020 оны цар тахлын гүн үед байсан 1.4 саяас доош түвшинд хүрсэн гэж мэдээллээ. Үүний нэгэн адил, пүрэв гарагт гарсан барилгын салбарын итгэлцлийн

### График 1. АНУ-ын S&P 500 индексийн ханшийн таамаглал







## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### Хятадын хөрөнгийн биржүүдийн холимог байдал

Шанхайн Composite Индекс 0.6%-иар өсөж, зах зээлд тодорхойгүй байдал багасаж, хөрөнгө оруулагчдын итгэл сэргэсэн байна. CSI 300 индекс 0.42%-иар нэмэгдсэн нь томоохон компаниудын тогтвортой байдалтай холбоотой. Хонг Конгийн Hang Seng Индекс 1.99%-иар өсөж, олон улсын эерэг дохио хөрөнгө оруулагчдыг өөдрөг байлгалаа (FactSet). Энэ өсөлтүүд нь зах зээлийн ерөнхий эерэг хандлагыг харуулж байна.

### Үйлдвэрлэл ба жижиглэн худалдаа хэвийн байна

Үйлдвэрлэлийн өсөлт жилд 5.1%-иар өссөн нь хүлээлтээс доогуур байсан (мөн зургадугаар сарын 5.3%-тай харьцуулахад буурсан). Энэ нь автомашины борлуулалт буурсантай холбоотой бөгөөд үйлдвэрлэлийн өсөлт саарсан нь хөрөнгийн зах зээлд ноцтой сөрөг нөлөө үзүүлсэнгүй. Жижиглэн худалдааны өсөлт 2.7%-иар өссөн нь хүлээлтийг давж, зургадугаар сарын 2%-аас сайжирсан байна. Энэ өсөлт нь дотоодын хэрэглээний эрэлт сайн байгааг харуулж, зах зээлд эерэг дохио өгч байна.

### Үл хөдлөх хөрөнгийн салбар ба ажилгүйдэл зах зээлийн хойш татаж байна

Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт жилийн өмнөхөөс 10.2%-иар буурсан нь зах зээлд сөргөөр нөлөөлж, хөрөнгө оруулалтын итгэлийг бууруулж байна. Хотын ажилгүйдлийн түвшин 5%-аас 5.2% болж өссөн нь хөдөлмөрийн зах зээлд сулрал байгааг харуулж, хэрэглэгчдийн итгэлд сөргөөр нөлөөлж байна.

### Хэтийн төлөв бүрэн сэргэх эсэх нь тодорхойгүй байна

Эдийн засгийн зарим үзүүлэлтүүд суларсан ч Хятадын төв банк хүү бууруулах магадлалтай гэсэн хүлээлт зах зээлд эерэг хандлага төрүүлж байна. Гэсэн хэдий ч үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн удаашрал хэрэглэгчдийн итгэлийг сулруулсаар байгаа нь зах зээлд тодорхойгүй байдал үүсгэж байна.

### График 2: Hang-Seng индексийн ханшийн таамаг



# ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН ОНЦЛОХ ТАЙЛАНГУУД

## Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS W WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning August 12, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
BARRICK	TERAWULF	NU	NU	Brinker INTERNATIONAL	CISCO	BABA	AMAT	ONECONNECT	
MONDAY.COM	FREIGHTER AMERICA	OCN	SurgePays	CardinalHealth	AST SpaceMobile	WMT	COHERENT	CINT	
ESPERION	adecoagro	MELCO	GoldRoyalty	MediWound	d.local	JD.COM	SIGMA LITHIUM AMERICA	Flowers Foods	
贝壳	PERSPECTIVE TECHNOLOGIES	SEA	OUSTER	CAE	ARCUTIS	JOHN DEERE	amcor		
CEPN	SUN LIFE	HUT 8	AVINO	DOLE	stone	NICE	H&R BLOCK		
ORLA MINING	CRESCENT	Paysafe	ZEVRA THERAPEUTICS	PFG	Grab	SON GOOD	ReNew POWER		
BALLARD	DHT	INTUITIVE MACHINES	INTAPP	PublicSquare	GEOPARK	ALVOTECH	despegar		
VUCHAI	rumble	HYZON	Lithium Argentina	Arco Dorados	LONGEVERON	GLobant	SHIMMICK		
ADAP	ARG	MindMed	Quantum	KAMADA	Lulus				
Adaptimmune	Arq								
YIMAB	KULR								
Yimab Therapeutics Inc.									

## Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS W WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning August 19, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
ZIM	paloalto	LOWE'S	Toll Brothers	TARGET	snowflake	Baidu	CAVA	UNITED FINANCIAL GROUP	
ESTÉE LAUDER COMPANIES	fabrinet	Medtronic	达达集团	macy's	zoom	OSIS	workday	HAFNIA	
FREIGHTOS	BIT DIGITAL	WORKHORSE LP	COTY	TJX	Wolfspeed	PELOTON	Bill.com		
API	agora	NAM	jack henry	ANALOG DEVICES	SYNOPSYS	Advanced Auto Parts	intuit		
AREC	AMERICAN RESOURCES CORPORATION	NANOX	LABOY	DYCOM	Agilent Technologies	BI'S	ROSS DRESS FOR LESS		
FLUENT	唯品会 vip.com	KEYSIGHT TECHNOLOGIES	YAMAHA	ZEEKR	URBAN OUTFITTERS	WILLIAMS-SONOMA	Red Robin		
PEPS	XPENG	SQM	ZTO 中通快递	满帮 Full Truck Alliance	Nordson	NetEase Games	Macro		
FLEXSTEEL	FUTU	ZTO 中通快递	emeren	Chemomab	mdxhealth	CanadianSolar	AMERIVA		
HESAI	Kingssoft Cloud	PagSeguro		GOS 万国数据	LUFAX	TD Bank	AMERICAN SOFTWARE		
E.C.D. AUTOMOTIVE DESIGN						bilibili			